



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 494

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөгжлийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 242,000,000.00 (хоёр зуун дөчин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 131,605,833.33 (нэг зуун гучин нэгэн сая зургаан зуун таван мянга найман зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргааны дарга Г.Лхачинжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

132001577

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 4.9.1 дугаар тогтоолын хавсралт

**Хөгжлийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг балансаас  
балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл/төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/	Хүлээн авах байгууллага
1	Тоёото Ланд крузейр-200 D маркийн суудлын автомашин, 60-86 УБА улсын дугаартай, арлын дугаар JTMHV05J004154397	2014	143000000	94,260,833.33	48,739,166.67	Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа
2	Тоёото Ланд крузейр-200 B маркийн суудлын автомашин, 88-00 УНЯ улсын дугаартай, арлын дугаар JTMHU09J3B4047246	2017	99000000	37,345,000.00	61,655,000.00	Үндэсний статистикийн хороо
			242,000,000.00	131,605,833.33	110,394,166.67	
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>242,000,000.00</b> (хоёр зуун дөчин хоёр сая)	<b>131,605,833.33</b> (нэг зуун гучин нэгэн сая зургаан зуун таван мянга найман зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө)	<b>110,394,166.67</b> (нэг зуун арван сая гурван зуун ерэн дөрвөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг жаран долоон мөнгө)	